



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 1/80
танай _____-ны № _____-т

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Д.АЛТАНГЭРЭЛ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд танай байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийж, аудитын тайлан, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлж байна.

Аудитаар өгсөн албан шаардлагыг тогтоосон хугацаанд нь зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 20-ны дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Хавсралт...¹⁷...хуудас.

ДАРГА, ТЭРГҮҮЛӨХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

D- alban bichig 2022 AS TOOT

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/148/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.10 № 2/06
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар тус байгууллага нь тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжихээр батлагдсаны дагуу Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлж байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын албан хэрэгцээний автомашинд 4,440.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийхдээ өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гаргуулаагүй, тус байгууллагын ажиллагсдын 1500.0 мянган төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг зөв тодорхойлоогүй зэрэг зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтрээгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 118 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.6 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна.

005020117

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,586,144.42	26,806,564.42
35	БАРАА МАТЕРИАЛ	32,586,144.42	26,806,564.42
35300	Бэлэн бүтээгдэхүүн	55,346.00	55,346.00
354	Хангамжийн материал	32,530,798.42	26,751,218.42
35410	Бичиг хэргийн материал	809,700.00	416,500.00
35420	Аж ахуйн материал	1,994,300.00	1,694,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,250,000.00	7,015,000.00
35440	Түлш, шатах тослох материал	87.42	87.42
35470	Бусад хангамжийн материал	24,476,711.00	17,625,131.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	567,803,518.65	593,814,934.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	567,803,518.65	593,814,934.35
392	Биет хөрөнгө	537,186,685.34	505,596,101.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	195,394,386.72	195,394,386.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14,896,200.55	-19,363,822.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	172,700,000.00	172,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-39,761,111.18	-73,544,444.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	327,430,318.00	396,367,626.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-120,602,678.36	-187,187,938.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,483,793.00	42,983,793.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,561,822.29	-21,753,499.29
393	Биет бус хөрөнгө	30,616,833.31	88,218,833.27
39301	Програм хангамж	1,580,000.00	1,580,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-988,166.69	-1,122,166.73
39303	Бусад биет бус хөрөнгө	30,025,000.00	87,761,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	600,389,663.07	620,621,498.77
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	175,000.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	175,000.00	00.00
413	Өглөг	175000.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	175,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	600,214,663.07	620,621,498.77
51	Засгийн газрын хувь оролцоо	600,214,663.07	620,621,498.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	328,802,027.70	386,538,027.70
51101	Өмч: - төрийн	328,802,027.70	386,538,027.70
512	Хуримтлагдсан үр дүн	209,518,515.62	172,189,351.32
51210	Өмнөх үеийн үр дүн	209,518,515.62	209,518,515.62
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-37,329,164.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	61,894,119.75	61,894,119.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	600,389,663.07	620,621,498.77

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	836,892,339.36	699,509,044.64
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	247,119,601.36	68,526,308.64
120	Нийтлэг татварын бүс орлого	247,119,601.36	68,526,308.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	247,119,601.36	68,526,308.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,084,233.36	1,899,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	176,035,368.00	66,627,308.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	62,510,838.00	630,982,736.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	528,211,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	528,211,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	527,261,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,967,768.00	102,478,816.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,967,768.00	101,478,816.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,124,570.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,124,570.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	1,418,500.00	292,520.00
133003	Хөрөнгийн	1,418,500.00	292,520.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	753,705,981.79	736,838,208.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	753,705,981.79	736,838,208.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	670,309,636.43	657,406,697.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,020,742.53	404,560,827.96
210101	Үндсэн цалин	405,065,869.86	335,054,818.96
210102	Нэмэгдэл	380,872.67	54,027,825.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	574,000.00	8,450,000.00
210104	Урамшуулал	00.00	7,028,184.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,514,561.47	50,769,005.66
210201	Тэтгэврийн даатгал	36,422,430.84	34,468,110.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,108,800.00	3,817,155.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,965,000.00	3,518,199.48
210204	Ажилгүйдлийн даатгал	753,500.00	815,037.32
210205	Эрүүл мэндийн даатгал	8,264,830.63	8,150,502.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,304,500.00	23,955,382.65
210301	Гэрэл, цахилгаан	2,438,480.00	2,361,408.65
210302	Түлш, халаалт	17,430,060.00	18,592,064.00
210303	Цэвэр, бохир ус	2,435,960.00	3,001,910.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,882,379.00	18,393,100.00
210401	Бичиг хэрэг	8,229,100.00	2,310,700.00
210402	Тээвэр, шатахуун	8,855,200.00	7,102,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	713,600.00	572,200.00
210406	Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,353,800.00	909,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	468,240.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	5,262,439.00	7,498,100.00
2105	Нормативт зардал	192,500.00	343,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	192,500.00	343,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,067,570.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	444,500.00	00.00
210604	Урсгал засвар	8,623,070.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	15,910,500.00	5,966,000.00
210702	Дотоод албан томилолт	15,910,500.00	5,966,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,145,724.00	403,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,561,124.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	72,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	268,900.00	173,250.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	216,700.00	157,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,271,159.43	153,015,931.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,568,468.00	44,854,038.54
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,702,691.43	108,161,892.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,396,345.36	79,431,511.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,016,000.00	2,750,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,016,000.00	2,750,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,773,077.36	5,892,222.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,773,077.36	5,892,222.73
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,607,268.00	70,789,288.46
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,607,268.00	70,789,288.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	83,186,357.57	-37,329,164.30
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	83,186,357.57	-37,329,164.30

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	664,938,471.36	632,589,216.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,084,233.36	1,899,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	71,084,233.36	1,899,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	71,084,233.36	1,899,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,084,233.36	1,899,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	593,854,238.00	630,690,216.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	528,211,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	528,211,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	527,261,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,467,768.00	102,478,816.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,467,768.00	101,478,816.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,124,570.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,124,570.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	654,339,071.36	622,779,216.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	654,339,071.36	622,779,216.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	570,942,726.00	543,347,704.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,660,810.00	404,735,827.96
210101	Үндсэн цалин	292,483,610.53	335,229,818.96
210102	Нэмэгдэл	86,526,899.47	54,027,825.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,880,100.00	8,450,000.00
210104	Урамшуулал	00.00	7,028,184.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,770,200.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,874,494.00	50,769,005.66
210201	Тэтгэврийн даатгал	38,615,494.00	34,468,110.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,064,700.00	3,817,155.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,251,800.00	3,518,199.48
210204	Ажилгүйдлийн даатгал	812,900.00	815,037.32
210205	Эрүүл мэндийн даатгал	8,129,600.00	8,150,502.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,304,500.00	23,955,382.65
210301	Гэрэл, цахилгаан	2,438,480.00	2,361,408.65
210302	Түлш, халаалт	17,430,060.00	18,592,064.00
210303	Цэвэр, бохир ус	2,435,960.00	3,001,910.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,496,400.00	10,509,500.00
210401	Бичиг хэрэг	4,793,400.00	1,925,200.00
210402	Тээвэр, шатахуун	8,855,200.00	7,102,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	713,600.00	572,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,134,200.00	909,500.00
2105	Нормативт зардал	343,000.00	343,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	343,000.00	343,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,820,070.00	00.00
210604	Урсгал засвар	7,820,070.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	14,149,500.00	5,966,000.00
210702	Дотоод албан томилолт	14,149,500.00	5,966,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,363,524.00	403,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,778,924.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	72,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	268,900.00	173,250.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	216,700.00	157,800.00

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,930,428.00	46,665,538.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,930,428.00	46,665,538.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,396,345.36	79,431,511.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,016,000.00	2,750,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,016,000.00	2,750,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,773,077.36	5,892,222.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,773,077.36	5,892,222.73
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,607,268.00	70,789,288.46
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,607,268.00	70,789,288.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,599,400.00	9,810,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,599,400.00	9,810,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,599,400.00	9,810,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,599,400.00	9,810,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,599,400.00	9,810,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,599,400.00	-9,810,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	328,802,027.70	63,805,955.27	124,595,322.53	517,203,305.50
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,911,835.52	1,911,835.52
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	328,802,027.70	63,805,955.27	126,507,158.05	519,115,141.02
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	83,186,357.57	83,186,357.57
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	328,802,027.70	61,894,119.75	209,518,515.62	600,214,663.07
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	328,802,027.70	61,894,119.75	209,518,515.62	600,214,663.07
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	328,802,027.70	61,894,119.75	209,518,515.62	600,214,663.07
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	57,736,000.00	00.00	00.00	57,736,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-37,329,164.30	-37,329,164.30
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	386,538,027.70	61,894,119.75	172,189,351.32	620,621,498.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Багтагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	528,211,400.00	522,319,177.27	5,892,222.73	98.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	528,211,400.00	522,319,177.27	5,892,222.73	98.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	525,406,500.00	519,569,177.27	5,837,322.73	98.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	408,144,700.00	404,735,827.96	3,408,872.04	99.2
210101	Үндсэн цалин	320,806,600.00	335,229,818.96	-14,423,218.96	104.5
210102	Нэмэгдэл	76,458,000.00	54,027,825.00	22,430,175.00	70.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,880,100.00	8,450,000.00	2,430,100.00	77.7
210104	Урамшуулал	00.00	7,028,184.00	-7,028,184.00	00.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,798,800.00	50,769,005.66	29,794.34	99.9
210201	Тэтгэврийн даатгал	35,245,500.00	34,468,110.54	777,389.46	97.8
210202	Тэтгэмжийн даатгал	3,888,300.00	3,817,155.37	71,144.63	98.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,110,600.00	3,518,199.48	-407,599.48	113.1
210204	Ажилгүйдлийн даатгал	777,700.00	815,037.32	-37,337.32	104.8
210205	Эрүүл мэндийн даатгал	7,776,700.00	8,150,502.95	-373,802.95	104.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,260,200.00	23,955,382.65	2,304,817.35	91.2
210301	Гэрэл, цахилгаан	2,070,300.00	2,361,408.65	-291,108.65	114.1
210302	Түлш, халаалт	20,915,200.00	18,592,064.00	2,323,136.00	88.9
210303	Цэвэр, бохир ус	3,274,700.00	3,001,910.00	272,790.00	91.7
2104	Хангамж, бараа материалын зардал	10,509,500.00	10,509,500.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	1,925,200.00	1,925,200.00	-	100.0

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
210402	Тээвэр, шатахуун	7,102,600.00	7,102,600.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	572,200.00	572,200.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	909,500.00	909,500.00	-	100.0
2105	Нормативт зардал	343,200.00	343,200.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	343,200.00	343,200.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	5,966,000.00	5,966,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	5,966,000.00	5,966,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	425,800.00	403,250.00	22,550.00	94.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,200.00	72,200.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	195,800.00	173,250.00	22,550.00	88.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	157,800.00	157,800.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	229,583,300.00	228,870,111.00	71,289.00	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,958,300.00	22,887,011.00	71,289.00	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	280,490.00	275,000.00	54,900.00	98.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,804,900.00	2,750,000.00	54,900.00	98.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,804,900.00	2,750,000.00	54,900.00	98.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	553,974,600.00	522,319,177.27	31,655,422.73	94.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	553,974,600.00	522,319,177.27	31,655,422.73	94.3
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	553,974,600.00	522,319,177.27	31,655,422.73	94.3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	36	38	-2	105.6
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	33	32	1	97.0
620003	Үйлчлэх ажилтан	2	3	-1	150.0
620004	Гэрээт ажилтан		2	-2	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,467,768.00	102,478,816.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,467,768.00	102,478,816.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,798,924.00	33,588,527.54
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,798,924.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,798,924.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		33,588,527.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		33,588,527.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,668,844.00	68,890,288.46
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,668,844.00	68,890,288.46
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	4,668,844.00	68,890,288.46
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,467,768.00	102,478,816.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,467,768.00	102,478,816.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,467,768.00	101,478,816.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь “Иргэдэд газар, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн болон газрын кадастрын талаарх төрөөс үзүүлэх үйлчилгээг ил тод, шударга, хөнгөн шуурхай үзүүлж, тэдний эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд

- *Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баримтлан барилга байгууламж барих газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн олгож ажиллана.*
- *Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж, ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор иргэн болгонд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлнэ.*
- *Геодези зураг зүйн орчин үеийн техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар аймгийн хэмжээнд газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч бүрийн анхан шатны бүртгэлийн хувийн хэрэг болон мэдээллийн санг бүрдүүлнэ.*
- *Газрын харилцааны талаар болон барилгын хяналтын улсын бүртгэлтэй холбогдсон төрийн үйлчилгээг нэг цэгээс, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хөнгөн шуурхай хүртээнэ.*
- *Барилга угсралтын ажлын чанар, зураг төслийн боловсруулалт, техникийн бичиг баримтын бүрдүүлэлт зэргэд барилгын норм дүрэм, стандартын шаардлагын дагуу хяналт тавьж ажиллана.*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын 2018 оны А/17 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлд ашиглаж санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,231.8 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
А	1	2	3	4	5	6
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,586.1	5.4%	26,806.6	4.3%	(5,779.6)	-17.7%
Мөнгөн хөрөнгө	-	0.0%	-	0.0%	-	-
Авлага	-	0.0%	-	0.0%	-	-
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	-
Бараа материал	32,586.1	5.4%	26,806.6	4.3%	(5,779.6)	-17.7%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	567,803.5	94.6%	593,814.9	95.7%	26,011.4	4.6%
Үндсэн хөрөнгө	762,613.5	127.0%	896,786.8	144.5%	134,173.3	17.6%
Хуримтлагдсан элэгдэл	(194,810.0)	-32.4%	(302,971.9)	-48.8%	(108,161.9)	55.5%
Нийт хөрөнгө	600,389.7	100.0%	620,621.5	100.0%	20,231.8	3.4%
Өр төлбөр	175.0	0.0%	-	0.0%	(175.0)	-100.0%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	600,214.7	100.0%	620,621.5	100.0%	20,406.8	3.4%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	600,389.7	100.0%	620,621.5	100.0%	20,231.8	3.4%

Бараа материалын дансны үлдэгдэл 26,806.6 мянган төгрөг болж 5,779.6 мянган төгрөгөөр буурсан нь сэлбэг хэрэгсэл дансны үлдэгдэл өмнөх оноос 1,765.0 мянган төгрөгөөр өссөн ч байгууллагын даргын 2022 оны А/48 дугаар тушаалын дагуу 7,498.1 мянган төгрөгийн бараа материал акталж данснаас хассан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 896,786.8 мянган төгрөг болж 134,173.3 мянган төгрөгөөр өссөн нь 9,810.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, 66,627.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газраас үнэ төлбөргүй хүлээн авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны А-1/2546 тоот албан бичгийн дагуу 57,736.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг шинээр бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 620,621.5 мянган төгрөг болж 20,406.8 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө дансны өсөлт бууралтын 57,736.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 37,329.2 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 787,273.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа, ажил үйлчилгээний зардлыг 233,013.8 мянга, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлыг 12,289.0 мянган төгрөгөөр бууруулж, 541,970.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 13,758.9 мянган төгрөгөөр хасаж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 528,211.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 528,211.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 522,319.2 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 5,766.0 мянга, холбооны суваг ашигласны хөлсийг 54.9 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллыг 71.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71504 Газрын зураглал, кадастр	528,211.4	522,319.2	5,892.2	98.9%
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	502,448.2	496,682.2	5,766.0	98.9%
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	2,804.9	2,750.0	54.9	98.0%
4	82404 Барилгын техник хяналт	22,958.3	22,887.0	71.3	99.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 1,000.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 101,478.8 мянга нийт 102,478.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 33,588.5 мянган төгрөгийг зарцуулж 68,890.3 мянган төгрөгийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 746 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 494,988.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,424.8 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурийг 2022 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгосон байсан ба жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар суурийг өөрчлөн сонгосон тул материаллаг байдлыг 11,052.6 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 оны 05 дугаар сард байгууллагын оффисын барилгын халаалтыг салгуулж байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан

ба энэ хүрээнд байр ашиглалттай холбоотой 2,304.8 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7.5 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, нийт 12 иргэн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан нийт 2.512.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий захиалагчийн техник хяналтын гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, цаашид шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 15,691.7 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	15,691.7	2	15,691.7	100.0
Нийт дүн	2	15,691.7	2	15,691.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,940.0, мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 4,440.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1,500.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

5.1.1. Тайлант хугацаанд тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй автомашинуудад нийт 4,440.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч засвар үйлчилгээ хийхдээ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд хийсэн урсгал засвартай холбоотой тооцооллыг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулан зөрчлийг арилгаж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5.1.2. Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7.5 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, нийт 12 иргэн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан нийт 2.512.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий захиалагчийн техник хяналтын гэрээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна..

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй 13 мэдээллийг нөхөн байршуулж, цаашид шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын барилгын хэлтсийн 5 албан хаагчид тус бүр 300.0 мянга нийт 1500.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг 2022 оны 12 дугаар сард олгохдоо нийгмийн даатгалд мэдээлээгүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид ажиллагсдын цалин хөлс түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалд үнэн зөв мэдээлж зөрчлийг давтан гаргахгүй байх.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй автомашинуудад сэлбэг хэрэгсэл худалдан авч засвар үйлчилгээ хийхдээ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13 дахь заалтыг хэрэгжүүлээгүй.	1	4,440.0			1	4,440.0		
Ажиллагсдын цалин хөлс түүнтэй адилтгах орлогыг үнэн зөв тодорхойлоогүй Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1 дэх заалтыг зөрчсөн.	1	1,500.0					1	1,500.0
Нийт дүн	4	5,940.0			1	4,440.0	1	1,500.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 7.5 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, нийт 12 иргэн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан нийт 2.512.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий захиалагчийн техник хяналтын гэрээг байршуулаагүй.	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		